

СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛ ТӨВ

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үйл явцыг үнэлэх нь:

ХАНДИВЫН ТАЛААРХ ХОРИГЛОЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2015 он

АГУУЛГА

НЭГ. МОНИТОРИНГИЙН ТАНИЛЦУУЛГА

- 1.1. Мониторингийн хэрэгцээ шаардлага
- 1.2. Зорилго, зорилтууд
- 1.3. Төслийн зохион байгуулалт
- 1.4. Мониторингийн аргачлал

ХОЁР. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

- 2.1 Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль дахь хандивын зохицуулалт, дүн шинжилгээ
- 2.2 Бусад хууль тогтоомж дахь хандивын зохицуулалт, дүн шинжилгээ
- 2.3 Засгийн газрын тогтоол, шийдвэр дэх хандивын зохицуулалт, дүн шинжилгээ

ГУРАВ. МОНИТОРИНГИЙН ДҮН

- 3.1 Хандив, бэлэг, санхүүгийн туслалцаа авах, хүсэхийг хориглох буюу 17.1 дэх заалтын хэрэгжилт
- 3.2 Хүлээн авч болох хандив, түүний зориулалт буюу 17.2 дох заалтын хэрэгжилт
- 3.3 Хандив авахын өмнө зөвшөөрөл авах буюу 17.3 дахь заалтын хэрэгжилт
- 3.4 Хандивлагчтай холбоотой шийдвэр гаргахыг хориглох буюу 17.4 дэх заалтын хэрэгжилт
- 3.5 Хандив цуглуулах, хүлээн авахыг хориглох нөхцөл буюу 17.5 дахь заалтын хэрэгжилт
- 3.6 Хандивтай холбоотой бусад тулгамдсан асуудал

ДӨРӨВ. МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- 4.1 Мониторингийн дүгнэлт
- 4.2 Мониторингийн зөвлөмж

ТАВ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

НЭГ. МОНИТОРИНГИЙН ТАНИЛЦУУЛГА

НЭГ. МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

2012 оны 01 дүгээр сард батлагдаж, 06 сараас хэрэгжиж эхэлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (цаашид Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль гэж товчлох)-ийн зорилго нь төрийн аль ч түвшний албан тушаалтны хувийн сонирхол албаны сонирхол хоорондоо зөрчилдөхөөс урьдчилан сэргийлэхэд оршдог. Сүүлийн үед “ашиг сонирхлын зөрчилгүй хүн”-ийг олж төрийн албанд ажиллуулах тухай ихээхэн ярьж байна. Угтаа бол ашиг сонирхлын зөрчилгүй хүн гэж байхгүй бөгөөд харин урьдчилан сэргийлээгүй, зохицуулаагүй, хянаагүй, шийдвэрлээгүй ашиг сонирхлын зөрчил аюултай гэдгийг ойлгох хэрэгтэй болоод байгаа.

Тус хуулиар дараах гол харилцааг зохицуулж байна. Үүнд,

- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх /төрийн байгууллага, албан тушаалтнууд юу хийх/
- Ашиг сонирхлын зөрчлийг хориглох болон хязгаарлах нөхцөлүүд /12 төрлийг тодорхойлсон/
- Ашиг сонирхлын мэдүүлэгтэй холбоотой
- Хуулийн хэрэгжилтийг хянах, хариуцлага хүлээлгэх.

Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль хэрэгжих эхлээд бараг 4 жил болж байгаа боловч “нийтийн албан тушаалтнуудад тавигдах хориглолт, хязгаарлалтыг зөрчих, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц шийдвэрүүд гаргах, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар үр ашиггүй зарцуулах” зэрэг зөрчлүүд гарсаар байна. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 17.1-17.5-д “Хандив авахтай холбогдсон хязгаарлалт”-ыг зохицуулсан бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтанд нийтийн хэрэгцээнд зориулан аливаа төрлийн санхүүгийн дэмжлэг, туслалцаа, хандив авахыг хориглосон байна. Гэтэл төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтнуудын дунд хамгийн их хавтгайрсан, түгээмэл байгаа зөрчил бол хандив болон хандивлагчтай холбоотой, түүнийг дагалдан гарч буй бусад ашиг сонирхлын зөрчлүүд байна. Тухайлбал, аливаа төрлийн “хандив” нь сайн дурын байх, тэгшитгээгүй байх, албадлагын бус байх атал “албан журмын”, “кампанит ажил” болгодог, тодорхой хувь хэмжээ, болзол тавьж нэхэж шаарддаг, түүнийг дагаад хандивлагч аж ахуйн нэгж байгууллагуудад илт давуу байдал олгодог, тэдэнд зориулсан шийдвэр гаргадаг, тэдэнд илүү ашигтайгаар төрийн үйлчилгээг хүргэж байна.

Хуулиар аливаа хориглолт, хязгаарлалтыг тогтоохдоо болгоомжлохгүй бол хуулийг тойрох, хийдлийг нь олж ашиглах, өөрт таатай байдлаар хэрэгжүүлэх

зэрэг сөрөг үр дагаварт хүргэх аюултай. Тиймээс өнөөдөр хандивтай холбоотой бий болоод байгаа олон асуудал нь хуулийн зохицуулалтанд байна уу, эсвэл түүнийг хэрэгжүүлж буй байгууллага, албан тушаалтны хүсэл зоригоос хамаарч байна уу гэдэгт баримт мэдээлэл цуглуулж, үнэлгээ хийх, цаашид эдгээр зөрчлийг зогсоох, урьдчилан сэргийлэх боломж, арга замыг бас хайх хэрэгцээ шаардлага байна.

ХОЁР.МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Энэхүү мониторингийн зорилго нь Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйл буюу “Хандив авахтай холбогдсон хязгаарлалт” гэсэн заалтын хэрэгжилтэд мониторинг хийх, мониторингийн үр дүнд үндэслэн хуулийн зохицуулалт, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн санал зөвлөмж боловсруулж, нөлөөллийн үйл ажиллагаанд хэрэглэх юм.

Төслийн зорилтууд:

- Зорилтот орон нутгийн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагууд дахь Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1-17.5 дахь заалтуудын хэрэгжилтэд үнэлгээ хийх, холбогдох кейс/тохиолдлыг судлах
- Зорилтот орон нутгийн холбогдох байгууллагуудад Төсвийн тухай хуулийн 25.2 дахь заалтын хэрэгжилтийг үнэлэх, ингэхдээ Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хандив авахыг зөвшөөрсөн болон хориглосон зохицуулалттай уялдаа холбоо, хамаарлыг судлах, Засгийн газрын 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг үнэлэх
- Хуулийг хэрхэн хэрэглэсэн тохиолдлуудад хийсэн дүн шинжилгээ болон судалгааны дүнд тулгуурлан хуулийн зохицуулалт болон хэрэгжилтийг сайжруулах талаар багц зөвлөмж боловсруулах, холбогдох талуудад түгээх, мэдээллээр хангах.

ГУРАВ.ТӨСЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төслийн баг 3 гишүүнтэй бөгөөд төслийн удирдагчаар Сонгогчдын Боловсрол Төвийн гүйцэтгэх захирал С.Оюунтуяа, төслийн судлаач зохицуулагчаар Д.Элбэрэл, мөн төслийн ажилтан Н.Оюунчимэг нар ажилласан болно. Судалгааны баг төсөл хэрэгжүүлэх хугацаанд үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөний дагуу судалгааг хийж гүйцэтгэсэн. Төсөл хэрэгжих хугацаанд судалгааны баг доорх зарчмыг удирдлага болгон ажиллав. Үүнд:

- Төрийн байгууллагаас хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүйгээр судалгааны ажлыг гүйцэтгэх
- Судлаачдын хувьд багийн зохион байгуулалтыг өндөр түвшинд баримтлан ажиллаж, мэдээллийг бүрэн гүйцэд цуглуулах
- Судалгаанд хамрагдсан төрийн байгууллага, албан тушаалтнууд болон тухайн байгууллагаар үйлчлүүлж буй хуулийн этгээд, иргэдээс судалгаа

авах, мэдээлэл цуглуулах явцад олж авсан мэдээллийг хууль бусаар ашиглахгүй бөгөөд зөвхөн судалгаа шинжилгээнд ашиглах зэрэг.

ДӨРӨВ.МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Энэхүү мониторингийн судалгааг 2015 оны 04 дүгээр сарын 1-ээс 2015 оны 08 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжүүлэв.

Мониторингийг анх төлөвлөхдөө бид шууд зорилтот аймгуудын төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан, үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгжээс мониторингийн анхдагч мэдээллийг авахаар аргачлалаа боловсруулсан юм. Төслийн баг мониторингийн мэдээллийг цуглуулахаар зорилтот аймгуудад очиж ажилласан боловч “хандив хүлээн авах угаасаа хуулиар хориотой”, “бид хандив авдаггүй”, “энэ талаар ямар ч мэдээлэл байхгүй, мэдээлэл гаргаж өгөх ч боломжгүй” гэсэн нэгэн ижил хариултыг авсан бөгөөд мониторингийн мэдээллийг анхдагч эх үүсвэрээс цуглуулах ажил мухардалд хүрсэн тул аргачлалаа өөрчилсөн болно. Тиймээс төслийн багаас Авлигатай тэмцэх газартай “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн хүрээнд Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хандивтай холбоотой хэсэгт холбогдох мэдээллийг авах хүсэлт гаргасан. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2014 онд авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлаар нийт 7 аймаг, 146 сум, 3 нийслэлийн дүүрэгт ажилласан ажлын тайлангаас Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйл буюу “хандив авахтай холбоотой хязгаарлалт”-д хамаарах тайлан, судалгаа, баримт, мэдээллийг түүвэрлэн ирүүлсэн нь энэхүү тайлангийн гол мэдээллийн эх сурвалж болсныг тэмдэглэж байна.

Иймд мониторингийн багаас мониторингийн судалгаанд эх сурвалж, баримт бичигт дүн шинжилгээ хийх, ярилцлагын аргыг түлхүү ашиглалаа.

1. Ганцаарчилсан ярилцлага - Энэ аргаар Авлигатай тэмцэх газрын “Соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх хэлтсийн ажилтнуудтай /эксперт/-ийн түвшинд ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан.
2. Кейс судлах - Авлигатай тэмцэх газраас аймаг, дүүргүүдэд хийгдсэн шалгалтын ажлын тайлангаас хандив авахтай холбогдсон хязгаарлалтын талаарх кейс баримтыг сонгон авч ажилласан.
3. Баримт бичиг судлах арга - Авлигатай тэмцэх газрын 2014 оны аймаг, дүүргүүдэд хийсэн ажлын тайлан, баримт бичгүүдийг судлан шинжлэхэд ашигласан.

Мониторингийн зорилго, зорилт, асуудлаас хамааран бид энэхүү тайланд орон нутаг, төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгжийн нэрийг шууд дурдаагүй бөгөөд үсэг, тэмдэгт ашиглан кодлож оруулсан болно.

ХОЁР. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

НЭГ.АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ДАХЬ ХАНДИВЫН ЗОХИЦУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталж, 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Тус хууль хэрэгжиж байх хугацаанд нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт орж, албан тушаалтнаас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт, албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа албан тушаалтанд тавих хязгаарлалт, хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн хүрээтэй холбоотой зохицуулалтыг илүү тодорхой болгож, ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн ойлголтыг шинээр хуульчилсан байна.

Энэхүү мониторингод хамаарах хандивтай холбоотой зохицуулалтыг тус хуулийн 17 дугаар зүйлээр зохицуулсан байна. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 3.1.8.-д “хандив” гэдгийг “нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэх”-ийг ойлгоно гэж заажээ. Эндээс үзэхэд аливаа төрлийн хандив нь үнэ төлбөргүй, мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй, түүнчлэн зах зээлийн бодит үнээс хямдралтай болон хөнгөлөлттэй үйлчилгээ, бараа материал зэрэг өргөн агуулга бүхий ойлголт болж байна.

17.1.Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Хуулийн энэ заалтаас үзэхэд ямар ч тохиолдолд төрийн байгууллага, албан тушаалтан аливаа төрлийн бэлэг, санхүүгийн туслалцаа, хандивыг хүлээн авах, авахыг хүсэх нь хориглогдсон байна.

17.2.Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Энэ заалтад хандив авч болох тусгай нөхцөлийг дараах байдлаар тогтоосон байна.

- Хандив өгч буй этгээд нь хандивыг хүлээн авч буй этгээдтэй албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээд байх
- Ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, санхүүгийн туслалцаа байх
- 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй байх.

Хандив, санхүүгийн туслалцааг хүлээн авч болох зориулалтын хувьд дараах зохицуулалт байна.

- Нийтийн албаны хэрэгцээ
- Ажилтны сургалт
- Үйл ажиллагааны зохион байгуулалт
- Техникийн дэмжлэг.

Хуулийн 17.1-д “нийтийн хэрэгцээ”-нд хандив авахыг хориглосон байтал 17.2-д “нийтийн албаны хэрэгцээ”-нд тодорхой нөхцөлийг хангаж байвал хандив авах боломжтой гэжээ. Эндээс харахад “нийтийн хэрэгцээ”, “нийтийн албаны хэрэгцээ” гэсэн нэр томъёонд ялгаа буй эсэх, “17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй” гэдгийг юу гэж ойлгох, “албан үүрэгтэй нь холбоогүй, ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив” гэдгийг ямар шалгуураар хэн тогтоох гээд олон асуулт эргэлзээтэй байна.

17.3.Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Энэ хуулийн 17.2-д заасан зориулалт, хандивлагч болон хандивт тусгайлан тавьсан нөхцөл болзлыг хангасан тохиолдолд хандив, санхүүгийн туслалцааг авах боломжтой бөгөөд энэ тохиолдолд тухайн хүлээн авагч этгээд өөрийн удирдлага, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахаар тусгажээ. Зөвшөөрөл авах хэлбэр, журам, түүнийг бүртгэх зохицуулалт энд алга байна.

17.4.Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Хандивлагчтай холбоотой үүсэх ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамгийн чухал зохицуулалтыг энэ заалтад тусгажээ. Гэхдээ хандивтай холбоотой мэдээллийг бүртгэх, хадгалах, түүнийг нийтэд мэдээлэх, тайлагнахтай холбоотой нарийвчилсан зохицуулалт, дүрэм журам байхгүй байна. Тиймээс хэн хандивтай холбоотой мэдээлэлд хяналт тавьж, энэ заалтын хэрэгжилтийг хангах нь тодорхой бус байна.

17.5.Албан тушаалтан дараах тохиолдолд биечлэн, эсхүл бусад этгээдээр зуучлуулан хандив хүсэх, хандив цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглоно:

17.5.1.хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд;

17.5.2.өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд;

17.5.3.өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Энэ заалтаар албан тушаалтан өөрт хамааралтай этгээдийн хэрэгцээнд зориулан өөрөө, эсвэл бусад этгээдээр зуучлуулан хандив хүсэх, цуглуулах, хүлээн авахыг хориглосон байна. Энэ нь албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд хандив авахыг хязгаарласан.

ХОЁР.БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ХАНДИВЫН ЗОХИЦУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Манай улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 430 орчим хууль байгаа бөгөөд үүний бараг 10 хувь нь буюу 40 хуульд “хандив”-тай холбоотой зохицуулалт байна. Эдгээр хуулийн 37-д нь хандив авахыг зөвшөөрсөн, 3 нь хандив авахыг хориглосон байна. Хандивыг зөвшөөрсөн хуулийг жагсаавал:

1. Авто замын тухай хууль /19.1, 19.1.5 дугаар зүйл/
2. Амьтны тухай хууль /15 дугаар зүйл/
3. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /13.2.1 дүгээр зүйл/
4. Ашигт малтмалын тухай хууль /42 дугаар зүйл/
5. Боловсролын тухай хууль /36.11.3, 39 дүгээр зүйл/
6. Барилгын тухай хууль /22 дугаар зүйл/
7. Бүсчилсэн хөгжлийн удирдлагын тухай хууль /16.1.2, 16.1.3 дугаар зүйл/
8. Дипломат албаны тухай хууль /7.1.7 дугаар зүйл/
9. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль /5.1.7, 84 дүгээр зүйл/
10. Дээд боловсролын тухай хууль /18.1.5 дугаар зүйл/

11. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /4.2, 5.1, 6.1.4, 7.1.2, 7.2.3, 8.4. 25.1 дүгээр зүйл/
12. Зээлийн батлан даалтын тухай хууль /7.5 дугаар зүйл/
13. Инновацийн тухай хууль /2.1, 12.1.8 дугаар зүйл/
14. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль /16.4 дүгээр зүйл/
15. Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль /22.1.4 дүгээр зүйл/
16. Нийгмийн халамжийн тухай хууль /7.1.3, 7.1.4 дүгээр зүйл/
17. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль /18.2 дугаар зүйл/
18. Ойн тухай хууль /31.1 дүгээр зүйл/
19. Олон нийтийн радио телевизийн тухай хууль /17.1.4 дүгээр зүйл/
20. Орон сууцны тухай хууль /11.1.3 дугаар зүйл/
21. Соёлын өвийг хамгаалах тухай хууль /19.9, 21.2 дугаар зүйл/
22. Соёлын тухай хууль /17.2, 21.1 дугаар зүйл/
23. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль /14.1.5 дугаар зүйл/
24. Тамхины хяналтын тухай хууль /10.3 дугаар зүйл/
25. Тариалангийн тухай хууль /13.2.4 дүгээр зүйл/
26. Төрийн өмчийн тухай хууль /6 дугаар зүйл/
27. Төсвийн тухай хууль /6.3.4, 43.1.5, 47.1.1, 59.1.3, 60.2.5/
28. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль /7.2.1, 6.2, 6.3 дугаар зүйл/
29. Харилцаа холбооны тухай хууль /11.2, 11.2.1 дүгээр зүйл/
30. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /8.1, 8.2 дугаар зүйл/
31. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /22.1, 22.1.6 дугаар зүйл/
32. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль /26.1.2 дугаар зүйл/
33. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль /16.1.3 дугаар зүйл/
34. Чөлөөт бүсийн тухай хууль /11.3.4 дүгээр зүйл/
35. Шинжлэх ухаан технологийн тухай хууль /14.1.4 дүгээр зүйл/
36. Монгол улсын эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /15.8 дугаар зүйл/
37. Эрдэнэсийн сангийн тухай хууль /10, 17.7.7, 24.1 дүгээр зүйл/.

Дээр жагсаасан 37 хуулийн 69 заалт нь “хандив”-тай холбоотой зохицуулалтыг агуулсан байх бөгөөд эдгээрийн 54 заалт буюу 78 хувь нь тухайн хуулиар зохицуулж буй харилцааг санхүүжүүлэх төсвийн болон сангийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөв, иргэн, хуулийн этгээдийн дэмжлэг, олон улсын тусламж, **“хандивын хөрөнгө”-өөр** санхүүжүүлэхээр зааж хандиваар бүрдүүлэхийг хүлээн зөвшөөрсөн байна. Түүнчлэн, дээр дурьдсан 69 заалтын 8 нь хандивыг тайлагнахтай холбоотой, 5 нь хандивтай холбоотой журам тогтоосон, дөнгөж 2 заалт нь хандивтай холбоотой журам зөрчвөл хариуцлага тооцох агуулга бүхий заалт байгаа юм. Эндээс үзэхэд хандив авахыг л зөвшөөрч зохицуулсан байгаа болохоос хандивыг яаж бүрдүүлэх, юунд зарцуулах, бүртгэл мэдээллийн тогтолцоо нь ямар байх, хэрхэн тайлагнах, зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдолд яаж хариуцлага тооцох зэргийг орхигдуулсан гэж хэлж болохоор байна.

Харин хандив авахыг хориглосон заалт агуулсан дараах хууль байна.

- Банкны тухай хууль. “7.4.Энэ хуулийн 7.1-д зааснаас гадна банк, түүний хараат болон охин компани дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:
 - 7.4.9.улс төрийн аливаа нам, эвсэлд хандив өгөх”.
- Монгол улсын шүүхийн тухай хууль. “28.6.Шүүх нь гадаад, дотоодын хувь хүн, хуулийн этгээдээс аливаа хэлбэрээр хандив, санхүүгийн туслалцаа авахыг хориглох бөгөөд үүнд Монгол Улсын олон улсын гэрээгээр нийлүүлэх эд хөрөнгө, зээл, тусламж, олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөр хамаарахгүй”.
- Тамхины хяналтын тухай хууль. “5.2.3.тамхи үйлдвэрлэгчээс төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг хүлээж авахаас татгалзах.
 - 8.4.Тамхи үйлдвэрлэгч шууд, эсхүл өөр байгууллагаар дамжуулан нийгмийн хариуцлага нэрийн дор нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, байгаль орчныг хамгаалах байгууллагад санхүүгийн болон эд материалын хандив, тусламж үзүүлэхийг хориглоно”.

Дээр дурдсан хууль тогтоомжоос Төсвийн тухай хууль нь Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулиар зохицуулсан “хандив”-тай холбоотой, хамгийн гол суурь хууль юм.

25.2.Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно.

25.2.1.эмнэлгийн үйлчилгээ

25.2.2.бүх шатны боловсролын үйлчилгээ

25.2.3.соёлын үйлчилгээ.

25.3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн авах тусламж, хандивын хэмжээ тухайн төсөвт байгууллагын батлагдсан төсвийн 50 хувиас хэтрэхгүй байна.

Төсвийн тухай хуулиас

Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлд “Тусламжийн орлого, түүгээр санхүүжих зарлага” гэдгийг тодорхойлсон бөгөөд “төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авах тусламж, хандив” нь тусламжийн орлогын нэг хэлбэр нь юм. Харин энэ хандив, тусламжийг зөвхөн нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллага, батлагдсан төсвийнхөө 50 хувь хүртэлх хэмжээгээр хүлээн авч болохоор байна.

Төсвийн тухай хуулийн 25.4 болон 25.5-аар хандивыг зөвшөөрөх тохиолдол болон хориглох нөхцөлийг зохицуулсан байна. Тухайлбал, төсвийн байгууллага нь

хөдлөх эд хөрөнгө болон мөнгөн хөрөнгөөр тусламж, хандив авч болох бөгөөд зориулалт нь дараах хоёр төрөл байна.

- санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх
- байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх.

Харин “ашиг сонирхлын зөрчилтэй” гэж үзэж хандив, тусламж авахыг дараах байдлаар хоригложээ.

25.5.Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно.

25.5.1.хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх

25.5.2.байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх.

Төсвийн тухай хуулиас

Түүнчлэн, хандивын орлогыг бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнаж байхаар тусгажээ. Эдгээр зохицуулалтаас харахад Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль болон Төсвийн тухай хууль дахь хандивын зохицуулалт нь хоорондоо зөрчилтэй, алийг нь дагаж мөрдөх нь тодорхойгүй, нэг асуудлыг өөр өөрөөр зохицуулсан байдал ажиглагдаж байна. Хандивын талаар зохицуулсан бусад хууль тогтоомжууд ч Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, Төсвийн тухай хуульдаа нийцээгүй, уялдаа холбоогүй байна.

ГУРАВ.ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭР БА ХАНДИВЫН ЗОХИЦУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол улсын Засгийн газрын 109 тоот тогтоол 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан. Энэ тогтоол нь Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх зорилготой.

Уг тогтоолын 1-р хэсэгт “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдөр, тодорхой салбар, байгууллагын ой, зарим ажил, мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тохиолдуулан ажилтан, албан хаагчдаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөнгөн шагналаар урамшуулахаар хүсэлт гаргах, **хандив, бэлэг, бусад санхүүгийн туслалцаа авах асуудлыг таслан зогсоохыг төсвийн захирагч нарт даалгасугай**” гэж заасан байна. Мөн тогтоолын 2 дох хэсэгт “Яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн байгууллага, тодорхой салбарын тэгш ойг

тэмдэглэн өнгөрүүлэхдээ Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ыг хатуу мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай” гэжээ.

Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хандивтай холбоотой 17 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн гэх энэ тогтоол нь дээр дурьдсан хоёр хэсгээс бүрдэх бөгөөд хандив, бэлэг, санхүүгийн туслалцаа авах асуудлыг “таслан зогсоох”-д чиглэгдсэн гэх боловч үүнийг ямар арга хэмжээ, үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлэх талаар ямар ч зохицуулалт байхгүй байна. Энэхүү 109 тоот тогтоол батлагдаад, хэрэгжээд 3 жил гаруй болж байгаа хэдий ч тогтоолын хэрэгжилтийг хангаж, дагаж мөрдөж буй албан тушаалтан, байгууллага цөөн байгааг мониторингийн дүн харуулж байна.

Мөн Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-д хандивтай холбоотой зохицуулалт байна. Тус журмын 3.8-д “Ойг тэмдэглэхэд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн улсын болон орон нутгийн төсөвт тусган батлуулна. Ойг тэмдэглэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн тодорхой хэсгийг **иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хандив, ивээн тэтгэгчдийн хөрөнгөөр санхүүжүүлж болно**” гэжээ. Ялангуяа төрийн бус байгууллагаас хандив хүлээн авахыг зөвшөөрсөн энэ зохицуулалтын нөлөөгөөр зөвхөн хандив авах зориулалтаар төрийн бус байгууллагуудыг олноор нь санаачлан байгуулж байгаа жишээ, баримтууд байна.

Сангийн сайдын 2010 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 45 тоот “Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журам”-ын нэгдүгээр хавсралтаар “Хандив, тусламжийг бүртгэх журам”-ыг баталсан байна. Уг журмын зорилго нь гадаадын болон дотоодын аж ахуйн нэгжээс төрийн байгууллагад өгч буй хандив, тусламжийг Нягтлан бодох бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад чиглэгддэг.

Хандив тусламжийг бүртгэхдээ

- Төрийн захиргааны байгууллага нь хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгийг холбогдох анхан шатны бүртгэлд тусгаж, тайлант хугацаанд санхүүгийн тайланд дараах байдлаар бүртгэж тайлагнана

а. Мөнгөөр хүлээн авсан үед:

Дт. Мөнгөн хөрөнгө

Кт. Хандив, тусламжийн орлого
б. Мөнгөн бус хөрөнгө хүлээн авсан үед зах зээлийн үнээр эсвэл гэрээнд заасан үнээр бүртгэнэ:

Дт. Бараа материал

Кт. Хандив, тусламжийн орлого

- Олборлох үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуй нэгжээс хандив, тусламжаар хүлээн авсан мөнгөн ба мөнгөн бус хөрөнгийг батлагдсан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын маягтаар тогтоосон хугацаанд гаргаж холбогдох газарт хүргүүлнэ.
- Төрийн захиргааны байгууллага хүлээн авсан хандив, тусламжийн орлогын талаар улирал, жилийн санхүүгийн тайланд тодруулгыг холбогдох Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу хийнэ.

Хандив, тусламжийг бүртгэх журмаас

Тус журмын 2.4-д “Хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгө, түүний зарцуулалтын талаар олон нийтэд зохих журмын дагуу мэдээлнэ” гэж заажээ. Энэ нь хандив, тусламжийн талаар мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгахад чиглэсэн ил тод байдлыг хангах чухал зохицуулалт боловч төрийн байгууллагууд энэ тал дээр хойрго ханддаг хэвээр байна. Түүнчлэн олон нийтэд мэдээлэх “зохих журам” гэдэгт юуг ойлгох, ямар арга хэлбэрээр, ямар хугацаанд, ямар давтамжтай, хэнд зориулан яаж тайлагнаж байхыг орхигдуулж байна.

ГУРАВ. МОНИТОРИНГИЙН ДҮН

Энэхүү мониторинг нь Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хандивтай холбоотой 17 дугаар зүйлийн хэрэгжилтийг үнэлэхийг зорьж буй тул мониторингийн дүнг хуулийн холбогдох заалт тус бүрээр харуулахыг зорилоо.

НЭГ. ХАНДИВ, БЭЛЭГ, САНХҮҮГИЙН ТУСЛАЛЦАА АВАХ, ХҮСЭХИЙГ ХОРИГЛОХ БУЮУ 17.1 ДЭХ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

17.1.Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Мониторингийн хүрээнд цугласан мэдээллээс үзэхэд хандив, тусламж нь дараах хэлбэртэй байна:

- Мөнгөн хөрөнгө /шууд бэлэн мөнгөөр хандив өгөх болон авах тохиолдол хамгийн түгээмэл байна/
- Хөдлөх хөрөнгө /автомашин, ёмкос, оффисын тоног төхөөрөмж, эксковатор зэрэг/
- Бараа материал /мал, мах, сүү, айраг, бензин шатахуун, асар майхан зэрэг/
- Үйлчилгээ /зочид буудлын, нийтийн хоолны, барилгын засвар үйлчилгээ зэрэг/

Тухайлбал, “Х” аймгийн “Б” суманд 2014 оны байдлаар 42.947.000 төгрөг, УАЗ-66 автомашин, 1 морь, 44 хонь, 11 ямаа, “Б” аймгийн 7 суманд нийт 731.692.634 төгрөг, 123 хонь, 29 ямаа, 1410 литр айраг, 51 кг ааруул, 21 ширхэг тогооны өрөм, 28 ширхэг бяслаг, 4 ширхэг ширмэл ширдгийг хандиваар цуглуулсан байна.

Хуулийн 17.1-д заасан зохицуулалтаар төрийн байгууллага албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авах нь бүү хэл, хүсэх хориотой, Төсвийн тухай хуулиар бол зөвхөн эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээнд хандив, тусламж авах боломжтой байгаа юм. Харин бодит байдал дээр төрийн байгууллага, албан тушаалтнуудын хүлээн авч буй хандив, санхүүгийн туслалцаа нь **сайн дурын** байх ёстой атал албадлагын шинжтэй, **тэгшитгээгүй байх** ёстой ч тодорхой норм, хэмжээ тогтоосон, хандив авахаар хүсэлт гаргах хориотой байтал өөрсдөө хандивлагчдад хандан гуйх эсвэл шахалт дарамт үзүүлдэг нөхцөл байдал түгээмэл болсон байна. Ингэж үзэх дараах шалтгаан байна.

- Аймаг, сум байгуулагдсаны ой, үндэсний баяр наадмыг тэмдэглэхтэй холбоотойгоор хандив цуглуулах зохион байгуулалттай үйл ажиллагааны

хүрээнд аймаг, сумдын Засаг даргын гарын үсэгтэй албан бичгийг орон нутгийн захиргааны байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэх

- Аймаг, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар хандив цуглуулах ажлыг хариуцан зохион байгуулах комисс, ажлын хэсгийг байгуулах
- Арилжааны банкуудад хандивын данс нээх
- Хандивыг төрийн бус байгууллагын болон орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн хүлээн авах
- Төрийн албан хаагчдын цалингаас зохион байгуулалттайгаар 1-2 хоногийн цалинг хандив гэж албан журмаар хураан авах
- Айл, өрх гэрээс тогтоосон мөнгөн дүнгээр хандив хураан авах, эсвэл мал бусад бараа материалыг татах
- Төсвийн байгууллагуудын цуглуулсан хандивын дүнг ажлын үзүүлэлт болгон журамлах
- Үзвэр, үйлчилгээ, концертын тоглолтын билетийг тарааж мөнгийг хураан авах
- Аж ахуйн нэгжүүдээс эзэмшдэг газрын га тутамд тариф тогтоож хандив авах
- Ашиглалтын болон хайгуулын лицензтэй аж ахуйн нэгжүүдээс Ашигт малтмалын тухай хуулийг барин байнгын, тогтмол, давтамжтайгаар хандив, тусламж авах байдал аймаг, нийслэл, дүүргүүдэд түгээмэл байна.

Жишээлбэл, зөвхөн нэг “К” аймгийн засаг даргын орлогч өөрийн бүх сумдын засаг дарга нарт Ю-1 албан бичгээр хандивын ажил зохион байгуулахыг даалгах тухай, Ю-2 дугаартай албан бичгээр Үндэсний их баяр наадам, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэх хүрээнд бүх шатны төрийн байгууллагын албан хаагчид нэг өдрийн цалин болон тоглолтын билетийн үнийг цалингаасаа суутгуулах тухай даалгасан байна. Тус аймгийн ойн арга хэмжээнд бараг нэг тэрбум төгрөгийн хандив цугласан байх бөгөөд төвлөрүүлсэн хандивын хэмжээ, эх үүсвэрийг доор харуулъя¹.

№	Хандивын эх үүсвэр	Хандивын хэмжээ
1.	Хандивын тоглолтын билетийн орлого	126.491.600
2.	Уул уурхайн аж ахуйн нэгж байгууллагаас	391.500.000
3.	Газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдээс	150.860.000
4.	Аялал жуулчлалын байгууллагуудаас	15.600.000
5.	Аймаг, сумдын төрийн албан хаагчдын 1 өдрийн цалингаас	99.400.000
6.	“О” аймаг дахь нутгийн зөвлөлөөс	29.560.000
7.	Сумдын уяачдын холбоо	35.310.000
8.	Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөл	15.900.000
9.	Бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас	54.983.100

¹ АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажлын хэсгийн орон нутагт ажилласан тайлангийн дүн мэдээ.

	Нийт хандивын дүн	919.604.700 төгрөг
--	--------------------------	---------------------------

Түүнчлэн, аймаг, сум, дүүргийн төрийн байгууллага, албан тушаалтнуудаас хандивын дэмжлэг, туслалцаа хүссэн албан хүсэлт, гуйлт /зарим тохиолдолд албан шаардлага болдог/ “явсан бичиг”-ийн нэлээдгүй хэсгийг эзэлдэг байна. Тухайлбал, “Ш” аймагт 4D эхогийн аппарат авахын тулд 20 удаагийн тохиолдлоор хуулийн этгээд, иргэдэд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн албан бичгийг явуулж, 87.000.000 төгрөгийг хандивлаач гэсэн хүсэлт гаргасан байх жишээтэй. Энэ нөхцөл байдлыг зөвхөн нэг “Ф” аймгийн жишээн дээр харуулъя.

№	Сумын нэр	Хандсан байгууллага, албан тушаалтан	Хандивын хэмжээ	Хандивын утга
1	“Т” сум	“Х” банк	500.000	Тэмцээн зохион байгуулахад дэмжлэг
2			882.000	Бөхийн барилдаан зохион байгуулахад дэмжлэг
3		“Э.Б.Т” компанид	500.000	Аймгийн гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний дэмжлэг
4		Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд	5.000	“Хүндэтгэлийн багана” босгох зардалд
5		“Д.З” төсөлд	-	Ухдаг зориулалттай тракторны үнийн дүнгийн 50 хувийг шийдэхэд дэмжлэг
6	“Э” сум	“Б.А.Э” компанид	-	Бохир соруулах автомашинтай болоход дэмжлэг
7	“З” сум	“Ш.У” компанид	-	90 жилийн ойн арга хэмжээнд мөнгөн дэмжлэг
8		“Б.А.Э” компанид	-	90 жилийн ойн арга хэмжээнд мөнгөн дэмжлэг
9	“О” сум	“Д.З” төсөлд	20.000.000	Бага оврын эксковатор худалдан авахад дэмжлэг
10	“Ц” сум	“Ж.И.” компанид	1.699.400	Өрөө, тасалгааны засвар үйлчилгээний зардалд хандив
11			4.955.000	Засаг даргын өрөөний тавилгыг шинэчлэхэд

Хандивыг хувь хэмжээ, норм тогтоож авч байгааг батлах олон жишээ, баримтууд байгаагийн нэгийг доор харуулав.

- “Ё” сумын засаг даргын 2013.07.02-ны 01/154 дугаартай албан бичгээр аж ахуйн нэгж, албан байгууллагын дарга, эрхлэгч багийн засаг дарга нарт

аймаг байгуулагдсаны 90-н жил, Ё хот байгуулагдсаны 280 жилийн ой, бүсийн “Хурд-2013” баяр наадам болохтой холбогдуулан сумын бүх хүмүүсийг хамруулан хандив цуглуулах ажлыг зохион байгуулах, мөн аймгийн баяр наадмын комиссоос өгч байгаа албан шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлэхийг мэдэгдсэн байна. Уг албан бичигт төрийн албан хаагчид 2 өдрийн цалин, хоршоо компанийн гишүүд, дундаж амьдралтай өрх 20.000 /хорин мянган/ төгрөг, өндөр настангуудтай өрх 10.000 /арван мянган/ төгрөг, 200-500 малтай өрх 50.000 /тавин мянган/ төгрөг, 500-1000 малтай өрх 100.000 /нэг зуун мянган/ төгрөг, 1000-аас дээш малтай өрх 400.000 /дөрвөн зуун мянган/ төгрөгийн хандив өгөхийг хүсжээ.

Дээрх хандивын мэдээллүүдээс харахад төрийн байгууллага, албан тушаалтнууд маш их хэмжээний буюу хэдэн зуун сая төгрөгөөр хандив босгодог, хандивыг босгох олон төрлийн арга, хэлбэрүүдтэй, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгж, олон улсын төсөл хөтөлбөрүүдээс хүртэл хандив тусламж нэхдэг, нийгмээс тусгай халамж шаарддаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс хүртэл албан журмаар хандив нэрээр мөнгө татдаг дүр зураг ажиглагдаж байна.

Ихэнх тохиолдолд хандив, тусламжийг цуглуулах ажил зохион байгуулалттай, нэгдсэн удирдлагатай, тогтсон төлөвлөгөөтэй байгаа нь хандивын сайн дурын, албадлагагүй, тэгшитгээгүй байх үндсэн зарчмыг нь гажуудуулсан, холбогдох хууль тогтоомжийг зөрчиж байгааг харуулж байна. Тухайлбал, “П” дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс 2014 оны 25 дугаар тогтоолоор дүүрэг байгуулагдсаны ойг тэмдэглэхэд шаардлагатай зардлыг орон нутгийн төсөв болон иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандиваар санхүүжүүлэх, хандивын орлогыг хүлээн авах, зарцуулах, тайлагнах журмыг баталсан байна. Энэ шийдвэрийг гаргахдаа Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолыг үндэслэжээ. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль болон Засгийн газрын 2012 оны 109 дүгээр тогтоолоор ийнхүү хандивыг зохион байгуулалттай цуглуулахыг хориглосон ч 2010 оны хандив цуглуулах боломж олгосон дээрх журам хүчин төгөлдөр хэвээр байгаа юм.

ХОЁР. ХҮЛЭЭН АВЧ БОЛОХ ХАНДИВ, ТҮҮНИЙ ЗОРИУЛАЛТ БУЮУ 17.2 ДОХ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

17.2.Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулиар төрийн байгууллага, албан тушаалтан аливаа төрлийн хандив, санхүүгийн туслалцааг нийтийн албаны хэрэгцээ, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэгт албан үүрэгтэй нь холбоогүй гуравдагч этгээдээс хүлээн авах боломжтой. Харин Төсвийн тухай хуулиар зөвхөн эх үүсвэр нь дутагдсан эмнэлэг, боловсрол, соёлын үйлчилгээнд болон сургалтын хөтөлбөрт л хандив, санхүүгийн туслалцааг хүлээн авах боломжтой юм. Бодит байдал дээр хандивыг хуулиар зөвшөөрсөн эдгээр зориулалтаар биш харин ихэнх тохиолдолд баяр наадам, тэмдэглэлт ой, тэмцээн уралдаан, хөшөө дурсгал босгох, байгууллагын нөөц бүрдүүлэх чиглэлээр цуглуулсан байгааг мониторингийн дүнгээс харж болно.

Албан тушаалтан, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын хүлээж авч байгаа хандив, санхүүгийн туслалцаа албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс байх ёстой шалгуур хэрэгжихгүй, харин ч эрхэлж буй ажил үйлчилгээ, түүнийг хамаарах нутаг дэвсгэрт харъяалагдаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд тухайн орон нутгийн гол хандивлагчид болоод байна. Тухайлбал, нийслэлийн “Я” дүүргийн “Дүүрэг хөгжүүлэх сан”-д хандив өгсөн аж ахуйн нэгж, иргэдийн хувьд:

- 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр 1.000.000 төгрөгийн хандив өгсөн “Б.Б.Г” компани нь тус дүүргийн нутаг дэвсгэрт нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулдаг
- 5 дугаар сарын 20-ны өдөр 5.000.000 төгрөгийн хандив өгсөн “Х.Х” компани нь тус дүүргийн 3-р хороонд тоосгоны үйл ажиллагаа эрхэлдэг
- 5 дугаар сарын 28-ны өдөр 500.000 төгрөг хандивласан “Ш.Н” компани тухайн дүүргийн нутаг дэвсгэрт жуулчны баазын үйл ажиллагаа эрхэлдэг
- 6 дугаар сарын 23, 6 сарын 27-ны өдөр тус бүр 200.000 төгрөг хандивласан “М.Ж”, “Х.Т” компани нь мөн жуулчны баазын чиглэлээр тухайн дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг байна.

Энэ нь хандив өгсөн аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээг авахад давуу тал болох, хандив өгөөгүй аж ахуйн нэгжүүдэд дарамт шахалт болох бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд хүргэх эрсдэл дагуулж байна.

ГУРАВ. ХАНДИВ АВАХЫН ӨМНӨ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ БУЮУ 17.3 ДАХЬ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

17.3.Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн

удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Аймаг, сум, дүүрэгт их хэмжээний хандивыг бүрдүүлэхдээ тухайн хандивыг хүлээж авсан төрийн байгууллага, албан тушаалтан өөрийн удирдлага, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан тохиолдол бүртгэгдээгүй байна. Ихэнх тохиолдолд хандивыг төрийн бус байгууллагын дансаар, эсвэл орон нутгийн төрөл бүрийн хөгжлийн сангаар дамжуулан авч байгаа бөгөөд энэ тохиолдолд хуулийн дээрх зохицуулалтыг тойрон гарах боломжтой болж байна.

ДӨРӨВ. ХАНДИВЛАГЧТАЙ ХОЛБООТОЙ ШИЙДВЭР ГАРГАХЫГ ХОРИГЛОХ БУЮУ 17.4 ДЭХ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

17.4.Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Төрийн байгууллага, албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хүлээн авсан хандив нь ямар нэгэн хариу болзолгүй байх ёстой бөгөөд хандив, туслалцаа үзүүлснийхээ төлөө ямар нэгэн давуу талыг төрийн байгууллага, албан тушаалтнаас хандивлагч бас олж авах ёсгүй. Тиймээс энэ зохицуулалт нь хандивлагчтай холбоотой үүсэх ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамгийн чухал механизм юм.

Бодит байдал дээр хуулийн энэ заалт хэрэгжихгүй, харин ч төрийн байгууллага, албан тушаалтан хандивлагчид зориулан шийдвэр гаргадаг тохиолдол байна. Тухайлбал, “К” аймгийн 2013 онд хүлээн авсан хандив, түүнтэй холбоотой гарсан хууль зөрчсөн, ашиг сонирхолын зөрчилтэй шийдвэрийн талаарх мэдээллийг доор харуулав².

№	Хуулийн этгээдийн нэр	Хандивын хэмжээ, зориулалт	Хандивлагчтай холбоотой гарсан шийдвэр, агуулга
1	“Т.У” компани	20.000.000 төгрөг	Сумын засаг даргын 2013 оны 05

² Авлигатай тэмцэх газар. “МОНПАК” авлигын эсрэг парламентын бүлэгт хүргүүлсэн албан бичгээс хуулбарлан авав.

			сарын 28-ны өдрийн 108 тоот захирамжаар 15 жилийн хугацаатай газар эзэмшүүлсэн.
2	“Р..н” компани	Морин хуур 10 ширхэг 5.000.000 төгрөг	Сумын засаг даргын 2013 оны 08 сарын 14-ний өдрийн 230 тоот захирамжаар 15 жилийн хугацаатай алт олборлох зориулалтаар газар олгосон.
3	“З.Д” компани	10 тн улаан буудай	Сумын засаг даргын 2013 оны 11 сарын 21-ний өдрийн 345 тоот захирамжаар 15 жилийн хугацаатай, үтрэмийн зориулалтаар газар эзэмшүүлэхээр болсон.

Мөн тус аймгийн “Ж” сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч гадаадын хөрөнгө оруулалттай “Т.Х” компани 160.000.000 /нэг зуун жаран сая/ төгрөгийн хандивыг орон нутагт үзүүлсэн байх бөгөөд үүний хариу болгож сумын засаг даргаас 2013 оны 06 сарын 21-ний өдрийн А/199 тоот захирамжаар уул уурхайн суурьшлын бүсийн барилга, байгууламжийн дэвсгэр газрын зориулалтаар эзэмшдэг газрыг 5 жилийн хугацаагаар сунгаж ашиглуулах шийдвэр гаргуулсан байх юм.

Хандивтай холбоотой бүртгэлийн систем, хяналтын тогтолцоо, олон нийтэд тайлагнах үйл явцыг зохицуулаагүй, хэн яаж хяналт тавих нь тодорхой бус байгаагаас хууль зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй, дур зоргийн шийдвэр гарах үйл ажиллагаа газар авсаар байгааг дээрх жишээ, баримтууд нотолж байна.

ТАВ. ХАНДИВ ЦУГЛУУЛАХ, ХҮЛЭЭН АВАХЫГ ХОРИГЛОХ НӨХЦӨЛ БУЮУ 17.5 ДАХЬ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

17.5.Албан тушаалтан дараах тохиолдолд биечлэн, эсхүл бусад этгээдээр зуучлуулан хандив хүсэх, хандив цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглоно:

17.5.1.хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд;

17.5.2.өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд;

17.5.3.өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

Энэ заалт нь албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон хамаарал бүхий бусад этгээдийн хэрэгцээнд хандив, туслалцааг хүлээн авахыг хориглосон зохицуулалт бөгөөд мониторингийн хүрээнд нийслэлийн “Ы” дүүргийн Бүртгэлийн хэлтсийн 2014 оны 01 дүгээр сарын 1-ээс хойш гадагш явуулсан албан бичигтэй танилцах явцад уг заалтыг зөрчсөн байж болох дараах кейс, баримтыг олж авсан болно.

- 2014 оны 12 сарын 08-ны өдрийн 973 тоот албан бичгээр “Ы дүүргийн И...а ХК-д” Бүртгэлийн байгууллага үүсэн байгуулагдсаны 74-н жилийн ойн баярыг угтаж тус хэлтсийг шагнаж өгөхийг хүссэн байна.
- 2014 оны 12 сарын 18-ны өдрийн 974 тоот албан бичгээр “Ы дүүргийн Улаан загалмайн хорооны дарга”-д Бүртгэлийн байгууллага үүсэн байгуулагдсаны 74-н жилийн ойн баярыг угтан тус хэлтсийг шагнаж өгөхийг хүссэн байна.

Энэхүү баримт нь төрийн байгууллага, албан тушаалтнууд үйлчлүүлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагад дарамт үзүүлж өөрийгөө шагнуулах зэргээр зохисгүй нөлөөлөл үзүүлдэг байж болзошгүйг харуулж байна.

ЗУРГАА. ХАНДИВТАЙ ХОЛБООТОЙ БУСАД ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Төрийн байгууллага, албан тушаалтан хандив хүлээн авахтай холбоотой дээр дурдсанаас өөр олон тулгамдсан асуудлууд мониторингийн хүрээнд ажиглагдсан болно.

Энэ хэсэгт хамгийн түрүүнд авч үзэх асуудал бол **хандивын хэмжээ, хязгаартай** холбоотой асуудал юм. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулиар хандив, санхүүгийн туслалцааны дүн, доод болон дээд хэмжээг хязгаарлаагүй, харин Төсвийн тухай хуулиар тухайн эх үүсвэр нь дутагдсан арга хэмжээ, үйл ажиллагааны зардлын 50 хувиас хэтэрч болохгүй гэсэн л хязгаарлалт байна. Ямар ч хориг, хязгаар байхгүй тул хандивт өгч байгаа мөнгөн дүнгийн хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулж бодоход асар өндөр дүнтэй байгаа юм.

Хандивын хэмжээтэй холбоотой дараагийн асуудал нь тухайн хандив, санхүүгийн туслалцаа нь тухайн хандивлагчийн **татвар төлсний дараах ашиг** мөн эсэх нь эргэлзээтэй байгаа, энэ чиглэлээр татварын асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын бүртгэж хөтөлсөн тайлан, тооцоо байдаг эсэхийг нягтлах, хандивыг татварын байгууллагын хяналттай уялдуулж өгөх нь зүйтэй юм. Төсвийн тухай хуулийн 25.9-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээд татвар ногдуулсны дараах ашгаас хандив, тусламж өгнө” гэжээ.

Түүнчлэн, Төсвийн тухай хуулиар “хандив хүлээн авсан этгээд тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, эсвэл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ” гэж байгаа ч энэ заалт хэрэгждэггүй болох нь

судалгааны явцад ажиглагдсан. Нөгөө талаас хандив өгсөн этгээд энэ тусламж, хандиваа хэрхэн тайлагнадаг талаар зохицуулалт байхгүй бөгөөд хүлээн авсан, өгсөн аль аль тал нь **ил тод, нээлттэй, нийтэд мэдээлдэг тогтолцоог** бий болгохгүй бол хандивын эмх замбараагүй, дур зоргоороо байгаа өнөөгийн төрхийг өөрчлөх боломж хомс байх юм. Өнөөдөр төрийн байгууллага, албан тушаалтны хүлээн авч байгаа хандивын талаар ямар ч тооцоо, бүртгэл байхгүй бөгөөд **зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь хяналтгүй, хаана, хэнд очиж байгаа нь ойлгомжгүй** байна.

Мөн Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулиар хандив, санхүүгийн туслалцааг бүртгэлжүүлэх талаар ямар нэг зохицуулалт байхгүй, Сангийн сайдын “Хандив, тусламжийг бүртгэх журам”-аар зохицуулагдахаар байгаа ч ийм тохиолдолд хандивын урсгалыг хянахад төвөгтэй байна.

Нөгөө талаар Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулиар төрийн байгууллага, албан тушаалтныг хандив авахыг шууд хориглонгуут орон нутгийн хөгжлийн чиглэлээр, эсвэл өөрийн гэр бүл, хамаатан садан, найз нөхдийн нэрээр **төрийн бус байгууллага шинээр байгуулж хандив авах**, хандивыг орон нутгийн өөр сангуудаар дамжуулан хүлээн авах, эсвэл арилжааны банкуудад хандивын данс нээлгэх зэргээр хуулийн зохицуулалтыг тойрч гарах нөхцөл байдал ажиглагдаж байна. Тухайлбал, “К” аймаг 90 жилийн ойд зориулан хандив авахдаа “Нутгийн хөгжилд миний оролцоо” төрийн бус байгууллагын дансаар нэг аж ахуйн нэгжээс 50.000.000 төгрөг, 2013 оны 05 сард “Жаргалант бүтээн байгуулалт” төрийн бус байгууллагыг шинээр байгуулж тус аж ахуйн нэгжээс ахин 50.000.000 төгрөгийн хандивыг энэ байгууллагын дансаар дамжуулан хүлээн авсан байна.

Үүний бас нэг төрөл нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хүрээнд уул уурхайн компаниудаас **“нийгмийн хариуцлагын гэрээ”** нэрийн доор авч байгаа хандив юм. Тус хуулиар “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана” гэжээ. Уул уурхайтай орон нутгууд энэ хуулийг мушгин “нийгмийн хариуцлагын гэрээ” гэдэг хуулиар тодорхойлоогүй, зохицуулаагүй халхавчийг ашиглан орон нутгийн захиргааны байгууллагуудаас аж ахуйн нэгжүүдэд хандив тусламжийг байнга, тогтмол үзүүлж байх санхүүгийн дарамт үүсгэх, захиргааны байгууллага өөрөө хууль бус хариу амлалт үүрэг хүлээх, эсвэл аж ахуйн нэгж байгууллагуудад хууль бус давуу байдал бий болгох зэргээр их хэмжээний хандив хөрөнгө босгож, энэ нь бизнесийн байгууллагад ч бэрхшээл бий болгож байна. Үүнийг Сант марал сангаас тогтмол зохион

байгуулдаг “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгааны дараах дүн батлан харуулж байна³.

- “Орон нутгийн захиргаа” бизнест бэрхшээл учруулдаг байгууллагуудын жагсаалтад тогтмол 4-т жагсаж байна.
- Бизнес эрхлэхэд учирч буй гол бэрхшээлийн 8-д “албан бус хураамж”-ийг бизнес эрхлэгчид нэрлэж байгаа бөгөөд энэ дүн 2014 оны 9 сарын байдлаар 11.7 болж бага зэрэг өссөн дүнтэй байна.
- Төрийн албанд авлига “маш их” болон “нэлээд их” байна гэж хариулсан бизнесийн байгууллага, оролцогчдын тоо 80 гаруй хувьтай, энэ үзүүлэлт буурахгүй тогтмол байгаа юм.

Хандивыг тайлагнах, хандивын хориглолтыг зөрчсөн тохиолдолд **хүлээлгэх хариуцлагыг авч үзэх** шаардлага байна. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 29.2.3-д зааснаар хандивтай холбоотой заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь **“албан тушаалыг нь бууруулах”** төдий байна. Хэдэн зуун сая төгрөгөөр тоологдох санхүүгийн туслалцаа, хандивыг хууль зөрчин хүлээн авсан тохиолдолд ийм хариуцлага ногдуулахаар байхад төрийн байгууллага, албан тушаалтан тухайн хуулийг нэг мөр дагаж мөрдөх, хэрэгжүүлэх эсэх нь эргэлзээтэй байна.

³ Сант марал сан, “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгааны тайлан, 2014 оны 10 сар.

ДӨРӨВ. МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

НЭГ. МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ

Мониторингийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хандивтай холбоотой зохицуулалтууд нь бие биеэ үгүйсгэсэн, зарим нэр томъёо, зохицуулалт нь хоёрдмол утга агуулсан, ойлгомжгүй, хандив хүсэх, хүлээн авахыг хориглосон тус хуулийн үзэл баримтлал нь бусад 40 орчим хуулиар үгүйсгэгдсэн, хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан тогтоол, шийдвэрүүд нь хэрэгждэггүй, тус хууль батлагдахаас өмнө гарсан хууль тогтоомжийг Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуульд нийцүүлэх ажил ч хийгдээгүй байна. Ялангуяа Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, хандив тусламж хүлээн авахдаа үндэслэл болгодог Засгийн газрын 172 тоот тогтоол зэрэг нь илт зөрчилтэй заалтууд агуулж байна. Түүнчлэн, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид “хандивыг хүлээн авах”-тай холбоотой зохицуулалт байхаас биш түүнийг яаж бүрдүүлэх, юунд зарцуулах, бүртгэл мэдээллийн тогтолцоо нь ямар байх, хэрхэн тайлагнах, зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдолд хэн, яаж, ямар хариуцлага тооцох талаар зохицуулаагүй гэж хэлж болохоор байна.
2. Эрх зүйн зохицуулалтын учир дутагдалтай, хоорондын уялдаа холбоогүй, иж бүрэн зохицуулалтгүй байдлыг ашиглан төрийн байгууллага, албан тушаалтнуудын хандив хүсэх, хүлээн авах, цуглуулах үйл ажиллагаа нэгдсэн удирдлага, тогтсон төлөвлөгөө, тодорхой аргачлалтай болж зохион байгуулалтанд орсон, дур зоргийн шинжтэй болсныг мониторингийн дүн харуулж байна. Төрийн байгууллага, албан тушаалтны хүсдэг, хүлээн авдаг хандив, тусламжийн дүн хэдэн зуун саяас тэрбум хүртэл төгрөгөөр яригддаг, хандивыг хүсэж, гуйх бус уул уурхайн томоохон компаниудаас эхлээд хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настнуудаа хүртэл хамруулдаг болжээ. Түүнчлэн, хандивтай холбоотой хуулийн хязгаарлалт, хоригийг тойрч гарах “нийгмийн хариуцлагын гэрээ” гэдгийг бий болгосон, төрийн бус байгууллагын дансаар дамжуулж хандив цуглуулдаг байдал газар авсан байна. Төрийн байгууллага, албан тушаалтны хүлээн авсан, цуглуулсан хандив нь хандивлагчийн татвар төлсний дараах ашиг мөн эсэхийг лавлах, баталгаажуулах боломжийг хуульд тусгаагүй байна.
3. Төрийн байгууллага, албан тушаалтны хүлээн авч буй хандив, санхүүгийн туслалцаа зэрэг нь сайн дурын байх ёстой атал албадлагын шинжтэй, тэгшитгээгүй байх ёстой ч тодорхой хувь, хэмжээ тогтоосон, зөвшөөрсөн болон хуулиар тогтоосон хандив авах нөхцөл хуулиар хумигдсан боловч хандивлагчдаас гуйдаг, болохгүй бол шахаж дарамталдаг нөхцөл байдал түгээмэл байгаа нь мониторингийн явцад ажиглагдлаа.
4. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулиар хандив, санхүүгийн туслалцаа авах зориулалтыг ялгаатай боловч тус бүрдээ тодорхойлсон байна. Гэтэл бодит байдал дээр хуульд заасан зориулалтаар биш баяр наадам, тэмдэглэлт ой, шагнал урамшуулал, хөшөө дурсгал,

оффисын тавилга, автомашин, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд зориулан хүлээн авсан байна.

5. Төрийн байгууллага, албан тушаалтны хүлээн авсан хандив, санхүүгийн туслалцааг дагалдаж олон төрлийн хууль зөрчсөн, ёс зүйгүй үйлдэл, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр олноор гарч байна. Ялангуяа хандив өгсөн иргэн, аж ахуйн нэгжид давуу тал олгодог, тэдэнд зориулан шийдвэр гаргадаг тохиолдол элбэг байна. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулиар хандивлагчтай холбоотой шийдвэр гаргахыг 2 жилийн хугацаанд хориглосон боловч бүртгэл, хяналтын систем байхгүй тул энэ заалт хэрэгжихгүй байна.

ХОЁР. МОНИТОРИНГИЙН ЗӨВЛӨМЖ

Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйл буюу хандив авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг үнэлээд дараах зөвлөмжийг гаргаж байна.

Нэг. Урт хугацаанд буюу Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн зохицуулалтыг сайжруулах

- Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуульд нийтэд нь үнэлгээ, мониторинг хийж, хандивтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг бүхэлд нь авч үзэж боловсронгуй болгох. Үүнд, хандив, тусламжийг авч үзэхдээ хориглож, хязгаарлахаас илүүтэй ил тод, нээлттэй, хэмжээ хязгаартай, түүнийг дагалдаж гарах бусад ашиг сонирхлын зөрчлүүдийг хаахуйц зохицуулалтыг шинээр авч үзэх.
- Ингэхдээ төрийн байгууллага, албан тушаалтан хандив авахтай холбоотой олон хууль тогтоомж дахь ялгаатай, зөрчилтэй, уялдаагүй зохицуулалтыг эргэн харж, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуульд нийцүүлэн авч үзэх.
- Төрийн байгууллага, албан тушаалтан нэг жилд хүлээн авч болох зөвшөөрөгдсөн хандивын хэмжээнд хязгаар тогтоох, мөн нэг этгээдээс, нэг жилд хүлээн авах хандивын хэмжээг хязгаарлах, хандивын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан хуулиар тогтоох. Мөн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нэг этгээдэд өгч болох хандив, нэг жилд өгч болох хандивын хэмжээг тогтоох.
- Хандив өгсөн хуулийн этгээд, иргэн тухайн үйл ажиллагаа болон адил төстэй үйл ажиллагаа, мөн тухайн байгууллага, албан тушаалтанд 2 жилийн хугацаанд дахин хандив өгөхийг хориглох.
- Хандивыг бүртгэх, ил тод нээлттэй мэдээлэх тогтолцоо, хүлээн авсан болон өгсөн хандивын талаар тусдаа тайлан хөтөлж, түүнийг тогтмол хугацаанд тайлагнадаг зохицуулалтыг бий болгох. Үүнийг татварын байгууллагын хяналттай уялдуулах байдлаар зохицуулах.
- Хандивтай холбоотой хуулиар тогтоосон журам зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, тухайн зохицуулалт хэрэгжих баталгаа болохуйц байдлаар хариуцлагыг тогтоох.

Хоёр. Богино хугацаанд буюу Ашиг сонирхлын зөрчлийн хуулийн хандив авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийг хангах

- Орон нутгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнуудад хандан хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас заавар, зөвлөмж тогтмол хүргүүлж ажиллах.
- Хандивтай холбоотой хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтнуудыг олон нийтэд зарлаж, хуульд заасан хариуцлага хүлээлгэх, үүнийг нөлөөлөл болгон ашиглах.
- Төрийн албан тушаалтнуудад Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулин 17 дугаар зүйлийг таниулах ажлыг сургалт, сурталчилгаагаар дамжуулан үе шаттай зохион байгуулах.

Гурав. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх

- Иргэд, олон нийтэд хандивтай холбоотой асуудлаар мэдээлэл өгөх, хуулийн хориглосон байдлыг таниулах, ямар ч тохиолдолд хандив нь сайн дурын байх зарчмыг ойлгуулах чиглэлээр сурталчилгааны кампанит ажлыг зохион байгуулж явуулж байх.
- Яам, агентлагаас авахуулаад орон нутгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнуудад хандивтай холбоотой хуулийн зохицуулалт, дүрэм журам зэргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны арга хэмжээг тогтмол зохион байгуулах
- Иргэд, аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагуудад хандивтай холбоотой хуулийн зохицуулалтыг таниулах, хандив шаардах, нэхэх тохиолдолд холбогдох байгууллагуудад мэдээлэх, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар сургалт, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулах, бизнесийн чиглэлээр ажилладаг мэргэжлийн холбоодтой энэ чиглэлээр хамтарч ажиллах
- Төрийн байгууллага, албан тушаалтны хандивтай холбоотой шийдвэр, үйл ажиллагаанд тогтмол хөндлөнгийн судалгаа, мониторинг хийж, үр дүнг нийтэд мэдээлж байх.

ТАВ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.
2. Төсвийн тухай хууль.
3. Авлигатай тэмцэх газрын 2014 онд аймгуудад ажилласан ажлын тайлан.
4. Авлигатай тэмцэх газар 2015 онд аймгуудад ажилласан ажлын тайлан.
5. С.Оюунтуяа, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, тулгамдаж буй асуудал” Сумдын засаг дарга нарын улсын зөвлөгөөн дээр тавьсан илтгэл, 2014он.
6. НДЭХ, Хуулийн хэрэгжилтийн үйл явцыг үнэлэх нь: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 7,8,9 дүгээр зүйл. Мониторингийн тайлан, 2014 он.
Сант марал сан, “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгааны тайлан, 2014 он.